



Захирагааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2020 оны 07 сарын 20-ны
өдрийн 4838 дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 07 сарын 03 өдөр

Дугаар A/369

Улаанбаатар хот

Г

Жагсаалт батлах тухай

Т

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10.4.2 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сургуулийн орчинд худалдаалахыг хориглох хүнсний бүтээгдэхүүний жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.
2. Энэхүү жагсаалтыг ерөнхий боловсролын сургуулийн орчны 150 м радиуст байрласан худалдаа, үйлчилгээний газруудад хүргэж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Аймаг, Нийслэлийн Засаг дарга наарт, мэргэшлийн зөвлөгөө, мэдээллээр хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв /Д.Нарантуяа/-д тус тус үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалтыг Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийг дагаж мөрдсөн өдрөөс эхлэн мөрдсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт даалгасугай.
5. Уг тушаал хүчин төгөлдөр болсон өдрөөс Эрүүл мэндийн сайдын "Журам батлах тухай" 2013 оны 207 дугаар тушаалын 3 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ

Эрүүл мэндийн сайдын
2020 оны 07 дугаар сарын 03...ны
өдрийн А/Б69 тушаалын хавсралт

СУРГУУЛИЙН ОРЧИНД ХУДАЛДАЛАХЫГ ХОРИГЛОХ ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЖАГСААЛТ

3.1.4. *Сургуулийн орчинд худалдаалахыг хориглох хүнсний бүтээгдэхүүний жагсаалт*

“Сургуулийн орчин” гэж сургуулийн байр, дотуур байр болон Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтад заасны дагуу сургуульд эзэмшүүлсэн газар, түүнээс эргэн тойронд 150 метр хүртэлх газрыг” хамруулан ойлгоно. Сургуулийн орчинд дараах хүнсний бүтээгдэхүүнийг худалдаалахыг хориглоно. Үүнд:

A. Ундааны зүйлс

1. Бүх төрлийн согтууруулах ундаа (архи, дарс, шар айраг)
2. Бүх төрлийн хийжүүлсэн ундаа
3. Энергийн болон спортын ундаа
4. Байгалийн бус өтгөрүүлсэн сироп, амт, өнгө, үнэр оруулж найруулсан шүүс, ундаа агуулсан байгалийн гаралтай жимсний ундаа (үзэм, нэрс, чацаргана, алимны ундаа гэх мэт)
5. Шошгын мэдээлэлд үндэслэн, Бүтээгдэхүүний 100 мл-т 10 г ба түүнээс их чихэр ундаа гэх мэт)
6. Өндөг болон элсэн чихрээр хийсэн коктейль

B. Амттан, зууш

7. Шошгын мэдээлэлд үндэслэн, Энгийн нүүрс ус ихтэй (100 г-д 10 г ба түүнээс их чихрийн агууламжтай) бүх төрлийн хатуу, зөвлөн чихэр, шоколад тэдгээрийн орцтой хүнсний бүтээгдэхүүн, мөхөөлдөс
8. Нийлэг буюу химиийн аргаар гаргаж авсан кремтэй бүтээгдэхүүн Бүх төрлийн чихэр (урлэн чихэр), хатаасан жимсийг жижиглэн болон ширхэгээр
9. Шаржигнуур төмс/ чипс, эрдэнэ шишийн хөөс/попкорн, давсалсан, бүрсэн самар
10. Шаардлага хангаагүй бохь (өнгө нь хувирдаг, хувирдаггүй XXL, 3D)

B. Боловсруулсан, хагас боловсруулсан хүнс, түргэн хоол

11. Хиам, зайдас зэрэг утсан, нөөшилсөн махан бүтээгдэхүүн
12. Бүх төрлийн чанадаг болон дэвтээдэг бэлэн гоймон
13. Тосонд шарсан ширхэгийн хоол (хуушуур, пирожки, шарсан тахиа, төмс, боорцог)
14. Даршилсан, давсалсан, нөөшилсөн ногoo
15. Шошгын мэдээлэлд үндэслэн, бүтээгдэхүүний 100 г-д 450 мг натри буюу 1.1г-аас их давс агуулсан бүх төрлийн хүнс
16. Шошгын мэдээлэлд үндэслэн, бүтээгдэхүүний 100 г-д 5 г-аас их ханасан өөх тос агуулсан бүх төрлийн хүнс
17. Транс тос агуулсан бүх төрлийн хүнс (шошгын мэдээллийг харах)
18. Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний болон дагалдах баримт бичиггүй, хаяг шошгогүй, буруу шошголсон, сав баглаа боодлын бүрэн бүтэн байдал алдагдсан, хадгалалтын горим зөрчигдсөн хүнсний бүтээгдэхүүн
19. Үйлдвэрлэсэн, хадгалах хугацаа эсхүл хэрэглэж дуусах хугацаа тодорхойгүй, хэрэглэж дуусах хугацаа хэтэрсэн хүнсний бүтээгдэхүүн
20. Бүх төрлийн халуун ногоо, хоол амтлагч